5. Хилийн орон зай дахь сөргөлдөгч талуудын үйл ажиллагааны төрөл, хэлбэр. давтамж

Б. Шууд бус, дам нөлөөлөх орчин нь:

1. Улс төр. нийгэм-эдийн засгийн

3. Хууль эрх зүйн

4. Хил залгаа улсын харилцаа, хамтын ажиллагаа

5. Цэрэг, техникийн хүчин чадал зэрэг нь үндэсний аюулгүй байдалд нөлөөх хүчин зүйл болно[1].

Улсын хил хязгаарын нөхцөл байдал гэдэг нь тухайн бүс нутгийн түүхэн болон доторхой цаг хугацааны гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг, харин хилийн цагийн байдал гэж шийдвэр гаргах мөчид өрнөж буй үйл явцын тухай ойлголт гэж тодорхойлж болох юм. Улсын хил дээр үүссэн хилийн зөрчил даамжирвал улсын хил хязгаарт аюул үүсгэх, түүнийг саармагжуулах, хариу үйлдлийг таслан хийхгүй бол өдөөн хатгалга. зэвсэгт халдлага, улмаар зэвсэгт мөргөлдөөнд хүрэх ноцтой үр дагавар байгаа юм. Орон нутгийн төрийн байгууллага, аж ахуй нэгж, ХХТХГ, ялангуяа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хил хамгаалалтад чиглүүлсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм.

Улсын хилийг хамгаалах асуудлыг зөвхөн хилийн орон зайд хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлдэг арга хэмжээ гэж үзэх нь учир дутагдалтай бөгөөд манайх шиг жижиг улсын хувьд олон улсын хэмжээнд улс төр, дипломатын аргаар, улс орны хэмжээнд төрийн бодлогоор зохицуулж, хилийн аюулгүй байдлаа ханган, хил хамгаалалтын арга тактик болон төрөл хэлбэрээ боловсронгуй болгох зайлшгүй шаардлага урган гарч ирж байна.

***М.Нармандах*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн*
*821 дүгээр дамжааны суралцагч, хошууч*

## ХИЛИЙН ЦЭРГИЙН УДИРДЛАГЫН ОНОЛЫН АГУУЛГА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЗАРЧИМ

***Хураангуй.*** *Хилийн цэргийн удирдлагын онол нь удирдлагын хууль, зүй тогтол, зарчим, хэлбэр, арга, удирдлагын системийн арга ажиллагаа болон хөгжлийн онцлогийн тухай шинжлэх ухааны мэдлэгийн цогц юм.*

***Түлхүүр*** *үг. Удирдлагын онол, хууль, зүй тогтол. хил хиамгаалах байгууллага, удирдлагын үндсэн зарчим.*

[1] Хил судлал сэтгүүл. 2015. №2.

Хил судлалын шинжлэх ухааны судлагдахууны бүрэлдэхүүн хэсэгт хилийн цэргийн байгуулалтын онол, хил хамгаалалтын урлагийн онол, хилийн цэргийн удирдлагын онол голлох байр эзэлдэг. Хилийн цэргийн байгуулалтын үндсэн асуудлын нэг нь цэргийн удирдлага бөгөөд түүний үндэс, зарчим, зүй тогтол, арга, зохион байгуулалт нь цэргийн болон нийгмийн шинжлэх ухааны судлагдахуунд чухал байр эзэлсээр байна[1]. Монгол оронд ардчилал, өөрчлөлт, шинэчлэлийн давалгаа ид өрнөж байсан 1990-ээд онд ямар арга барилаар яаж ажиллаж байгууллагаа хэрхэн яаж аварч, авч үлдэх, цаашид ямар арга барилаар хөгжүүлэх нь бүх шатны удирдагч нарын тулгамдсан асуудал, тулгарсан зорилт болж байлаа. Тухайн үед хил хамгаалах байгууллагын удирдлага бий болсон бодит байдлыг шийдэх "гарц"-ыг олохын тулд өнгөрсөн, одоо, ирээдүйн харилцан хамаарал, уламжлал шинэчлэлийн онол арга зүйн үндэс, шалтгаан үр дагаврыг олон талаас нь үнэлэн дүгнэж, түүнд ул суурьтай хандан хөгжил дэвшилд хүргэсэн орчин үеийн удирдахуйн шинжлэх ухааны онол арга зүйг удирдлагынхаа үндсэн чиг баримжаа болгох нь чухал юм гэдгийг ойлгож мэдэрсэн.

Орчин үеийн удирдахуйн ухааны хөгжлийн чиг хандлага, онол арга зүйд үндэслэн байгууллагаа хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж эрмэлзэх зүйл, эрхэм дээд зорилго, зорилт түүнийгээ хэрэгжүүлэх арга барилаа тодорхойлж, хүнлэг чанар, шударга ёс, үр дүнг үйл ажиллагааныхаа үндсэн зарчим болгон ирсэн.

Өмнөх үеийн түүх. өнгөрсөн үйл явдлын үр дагаврыг тал бүрээс нь нягтлан дүгнэж, аливаа шийдвэрийг гаргахдаа стратегийн хэмжээнд алсын хараатай, өргөн цар хүрээтэй сэтгэж, үйл ажиллагаагаа хамт олны сэтгэл зүй, үзэл бодлыг үндсэн үүрэг. зорилгоороо бахархах, түүнийгээ сэтгэл зүтгэл гарган биелүүлэхэд чиглүүлэн өөрчлөх нь зөв удирдлагын нэг үндэс юм. Хил хамгаалах байгууллагын одоогийн удирдлага тухайлбал хошууч генерал Ц.Сэргэлэн уламжлал, шинэчлэл, удирдлагын залгамж чанарыг хадгалан удирдахуйн онол, шинжлэх ухааны мэдлэг ололтыг дээдлэн хүнээ хөгжүүлэх, итгэл өгч бие даалгах, хил хамгаалалтын эрх зүйн орчинг талаар зорилтуудыг дэвшүүлж, шийдвэртэй арга хэмжээ авч байгаа нь чухал алхам хэмээн үзэж байна.

Монгол Улсад орчин үеийн хил хамгаалах байгууллага үүсч хөгжсөн 80 гаруй жилийн хугацаанд цэргийн шинжлэх ухааны доктор хошууч генерал П.Даш "Хил хамгаалалтын онол", цэргийн шинжлэх ухааны доктор

[1] *Ц.Цэрэндорж, С.Цэрэндамба* нар. Бидний менежмент. -УБ,, 2010. 6 дахь тал.

хурандаа Н.Наранжамц “Улсын хил хамгаалалтын онол-практикийн үндсэн асуудлууд", цэргийн шинжлэх ухааны доктор хурандаа Д.Нямдорж "Хил судлал"[1] номондоо хилийн цэргийн удирдлагын онолын талаар тодорхойлон дурдсан байна.

Шинжлэх ухаанд ерөнхий асуудлаас тодорхой руу шилжин судлах арга зүй байдаг. Энэ нь тухайн тодорхой асуудалд хандахдаа ерөнхий асуудлаа зөв ойлгож, нэгдсэн тодорхой ойлголттой болох зайлшгүй шаардлагатай байдагтай холбоотой.

Энэ үүднээс хилийн цэргийн удирдлагын онолын тухай асуудлыг авч үзэхдээ эхлээд удирдлагын тухай ойлголт, ерөнхий онол, түүний мөн чанар, агуулга. нийтлэг хуулиуд зэрэг үндсэн асуудлуудад нь анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

Цэргийн удирдлага гэдэг нь дан ганц зэвсэгт хүчин, түүний нэгдэл. нэгтгэл, ангиудыг удирдах тухай ойлголт биш, үүний дээр мөн улс орны батлан хамгаалах төрийн цэргийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдол бүхий бүх асуудлаар байгууллага, иргэдийг удирдах тухай ойлголт юм.

*Цэргийн удирдлага* гэдэг ойлголтыг ерөнхий утгаар нь авч үзвэл улс орон, зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдал, байлдах чадвартай байлгах операци болон байлдааны ажиллагаанд бэлтгэх, тавигдсан үүргийг биелүүлэх үед нь удирдах асуудлаарх төрийн дээд болон зэвсэгт хүчний удирдах байгууллагуудын чиглэсэн зорилготой үйл ажиллагаа юм.

Цэргийн шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн түвшинд цэргийн удирдлагын тухай ойлголт нь мэдлэгийн бие даасан салбар болж, улмаар цэргийн удирдлагын онолын хэмжээнд өргөжин хөгжиж байна. Ингэснээр удирдлагын болон цэргийн шинжлэх ухаанд түүний эзлэх байр, гүйцэтгэх үүрэг, судлах зүйл, судалгааны чиглэл, арга хэлбэр нь улам тодорхой болж байна. Энэ агуулгаар цэргийн удирдлагын онол нь удирдлагын шинжлэх ухааны ололт, амжилтыг бүрэн дүүрэн ашиглаж, цэргийн шинжлэх ухааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хандлагатай байна.

Хөгжлийнхөө өнөөгийн төвшинд “Цэргийн удирдлагын онол" нь удирдлагын үндсэн категори, ойлголтууд болон зүй тогтол, зарчмуудыг өөртөө багтааж, цэргийн байгууллага, түүний бүрдэл хэсгүүдийн үйл ажиллагааны онол, практикийн туршлагыг нэгтгэн дүгнэсэн, цэргийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, удирдлагын үр ашигтай үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг агуулсан шинжлэх ухааны үзэл баримтлалын цогц мөн хэмээн тодорхойлогдож байна.

[1] *Х.ПүрэвОавга.* Менежмент. -УБ., 2009. 15 дахь тал.

***Цэргийн удирдлагын онолын үндсэн агуулга*** нь танин мэдэхүйн болон урьдчилан төсөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

***Цэргийн удирдлагын зарчим нь*** цэргийн удирдлагын хууль зүй тогтлыг цэргийг удирдах практик үйл ажиллагаатай холбож өгдөг гүүр ч гэж хэлж болно. Цэргийн удирдлагын үр дүнг дээшлүүлэхэд цэргийн удирдлагын зарчим чиглэгдэнэ.

Удирдахуйн ухааныг мэдэхгүйгээр үр ашигтай удирдах боломжгүй бөгөөд удирдлагад захиргааны аргыг шинжлэх ухаантай хослуулж байж үр дүнд хүрдгийг судалгаагаар нэгэнт нотолсон билээ.

Хилийн цэргийн удирдлагын онол нь удирдлагын хууль, зүй тогтол. зарчим, хэлбэр, арга, удирдлагын системийн арга ажиллагаа болон хөгжлийн онцлогийн тухай шинжлэх ухааны мэдлэгийн цогц юм.

Цэргийн удирдлагын онолын зарчмын үндсүүд болон зүй тогтлуудыг өргөн ашигладаг хэдий ч хилийн цэргийн алба-байлдааны үйл ажиллагааны онцлог нь улсын хил хамгаалах салбарын удирдлагын онолд өөрийн мөрөө үлдээсэн.

Эдгээр асуудлыг зөв ойлгож, онолын үндсэн зарчим, хууль, зүй тогтлыг зөв хэрэглэх нь хилийн цэргийн улсын хил хамгаалах болон тусгай үүрэг гүйцэтгэх ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйлийн нэг мөн.

Хилийн цэргийн удирдлагын онолын судлах зүйлд удирдлагын хууль, зүй тогтол, шаардлага, зарчим, зохион байгуулалтын хэлбэр, техникжсэн, автоматчилагдсан байдал, удирдлагын системийн хөгжил, удирдах үйл ажиллагааны аргачлал зэрэг орно.

Хилийн цэргийн удирдлагын онол нь өөрийн *судлагдахууныг* тэдгээрт нөлөөлдөг төрөл бүрийн хүчин зүйлийн оролцоотойгоор судалдаг. Хүчин зүйлүүд нь тус тусдаа илрэн гардаг боловч, өөр хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг.

Удирдлагад эдгээр хүчин зүйлс нөлөөлснөөр түүний ерөнхий хууль. зүй тогтлын үйлчлэл илэрч, энэ нь удирдлагын асуудлыг чиглэл зорилготой, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэх боломж олгодог байна. Хилийн цэргийн удирдлагын онолын агуулга нь Улсын хил хамгаалалтыг тасралтгүй, шуурхай, үр дүнтэй удирдахын тулд удирдлага оновчтой тогтолцоотой байх, удирдах байгууллагын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион • байгуулах, удирдлагын орчин үеийн дэвшилтэд аргыг сонгон хэрэглэх шаардлагатай болно.

Хилийн цэргийн удирдпагын тогголцоог хоорондоо зохицсон зохион байгуулалт бүхий цэргийн удирдлагын байгууллага, байр хийгээд бие

бүрэлдэхүүнийг удирдах холбооны болон мэдээллиин сүлжээний нэгдсэн нэг бүхэл цогц гэж тодорхойлж болох юм.

Хилийн цэргийн удирдлагын онол нь нийгэм, эрх зүй, мэдээлэлжүүлэлтийн шинжлэх ухааны ололтыг ашиглан удирдахуйн болон цэргийн шинжлэх ухааны объектив хуулиудын илрэлд тулгуурлан удирдлагын зүй тогтлыг тоггоож, хилийн цэргийн удирдлагын зарчим, зохион байгуулалт, ажлын дэвшилттэй арга барилыг боловсруулдаг байна.

Хилийн цэргийн удирдлагын онолын үндэс, хууль, зүй тоггол, зарчим, арга зүй, зохион байгуулалт нь цэргийн болон удирдахуйн шинжлэх ухааны хөгжлийн өнөө үед харьцангуй бие даасан судлагдахуун боллоо. Ер нь захирагч, дарга нар цэргийн болон удирдахуйн удирдлагын онолын мөн чанар, зорилго, агуулгын талаар шинжлэх ухааны үндэстэй мэдлэгтэй байснаар төр, засаг, цэргийн командлалаас хүлээлгэсэн үүргийг амжилттай хэрэгжүүлэх, түүнд бүтээлчээр хандах үндэс суурьтай болдог.

Удирдлагын болон цэргийн шинжлэх ухааныг судлах, шинжлэх ухааны үндэстэй удирдах ухаанд суралцах гэсэн хүсэл, тэмүүлэл хил хамгаалах байгууллагын удирдагч нарын нэгэн онцлог шинж төрхийн илэрхийлэл болоод байна. Хил хамгаалах байгууллагын жишээн дээр дээр дурьдсан үйл ажиллагааны арга хэлбэрүүдийг нарийвчлан авч үзэх юм бол улсын хил хамгаалалт нь өөрийн мэргэжлийн өвөрмөц онцлог, арга хэлбэрүүдээрээ бусад хүчний байгууллагуудын үйл ажиллагаанаас өөр болох нь тодорхой харагдана.

Улсын хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа нь улсын хилийг газар, усан дээр манаж хамгаалах, хүн, ачаа тээш, тээврийн хэрэгслийг улсын хилээр шалгаж нэвтрүүлэх, хил зөрчигчид, хорлон сүйтгэгчид, алан хядагчидтай тэмцэх, хүчний болон хил хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус хил дамнасан наймаа (контрбанд)-тай тэмцэх, хүн, тээврийн хэрэгсэл улсын хилийг хууль бусаар нэвтрэх явдлыг таслан зогсоох зэрэг үйл ажиллагаагаар ялгардаг.

Хилийн цэргийн удирдлагын онолын агуулгын хэрэгжүүлэх зарчмыг орчин үеийн цэргийн болон менежментийн шинжлэх ухааны чиг хандлага, ойлголтод түшиглэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын түвшинд судлан тодорхойлох нэн шаардлагатай байна.

Хилийн цэргийн удирдлагын онолын агуулгын хэрэгжүүлэх үндсэн зарчмыг удирдахуйн болон цэргийн удирдлагын ерөнхий зарчмууд, хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрмийн зарчмуудад тулгуурлан өөрийн байгууллагын онцлогт тохирсон өвөрмөц маягаар боловсруулах нь зүйтэй.